



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/153

Хатан суудал

Тамхи худалдаалах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8 дугаар зүйлийн 8.2.11.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хатансуудал 5 дугаар багийн нутагт байрлах “Тулга” хүнсний дэлгүүрт тамхи худалдаалах зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгосугай.

2.Тамхины хяналтын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг “Тулга” дэлгүүрийн эзэн (Г.Отгонзаяа)-д үүрэг болгосугай.

3.Худалдаа үйлчилгээний цэгт холбогдох хууль тогтоомж, цагийн хуваарийг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Б.Бадарчин)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Гантулга)-д даалгасугай.



ДАРГА

С.ЭНХЗУЛ

842401317



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/154

Хатан суудал

Тамхи худалдаалах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8 дугаар зүйлийн 8.2.11.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хатансуудал 5 дугаар багийн нутагт байрлах “Цагаан уул” хүнсний дэлгүүрт тамхи худалдаалах зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгосугай.

2.Тамхины хяналтын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг “Цагаан-Уул” дэлгүүрийн эзэн (Ж.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

3.Худалдаа үйлчилгээний цэгт холбогдох хууль тогтоомж, цагийн хуваарийг мөрдүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Б.Бадарчин)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642401319



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/158

Хатан суудал

**Шуурхай штаб шинэчлэн
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Гамшгаас хамгаалах бүх шатны бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажиллах Шуурхай штабын шинэчилсэн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Гамшгаас хамгаалах бүх шатны бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Шуурхай штабын бэлэн байдлыг хангаж үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллахыг Шуурхай штабын дарга, Засаг даргын орлогч (С.Эрдэнэбаяр)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/117 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



С.ЭНХЗУЛ

642491329

Сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн 1/158 дугаар
захирамжийн хавсралт



ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Шуурхай штабын дарга: С.Эрдэнэбаяр (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Х.Түвшинбилэг (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Гишүүд: Г.Мөнхсүх (Засаг даргын тамгын газрын дарга)

Ц.Жаргалболд (Зэвсэгт хүчний 103 дугаар тусгай салбарын захирагч)

С.Цэдэндорж (Сургуулийн захирал)

А.Цэндмаа (Соёлын төвийн эрхлэгч)

Д.Нансалмаа (ЭМТ-ийн дарга)

А.Мөнхзул (Цэцэрлэгийн эрхлэгч)

Ш.Хоролсүрэн (Санхүү албаны дарга)

Н.Цэрэндолгор (Мал эмнэлэгийн тасгийн дарга)

Б.Бадарчин (Хэсгийн төлөөлөгч)

Н.Мөнхгэрэл (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Б.Адъяанасан (Эрчим хүчний ажилтан)

Х.Бямбажаргал (Цаг уурч)

Д.Батаа (Иххалбаганат 1-р багийн Засаг дарга)

Ц.Намхайхорол (Баян-Аараг 2-р багийн Засаг дарга)

А.Элдэв-Очир (Бага Баян 3-р багийн Засаг дарга)

С.Баттулга (Их Баян 4-р багийн Засаг дарга)

Б.Амаржаргал (Хатансуудал 5-р багийн Засаг дарга)

.....000.....



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/153

Хатан суудал

**Сумын орон тооны бус мэргэжлийн ангийн
бүрэлдэхүүнд тодотгол хийх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар батлагдсан дүрмийн 1.3, 1.9, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын орон тооны бус мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулж, дадлага сургуулилт хийлгэж байхыг Мэргэжлийн ангийн дарга (С.Эрдэнэбаяр)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/116 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642401333



وڪس سمن ٿيڻ بعد ڪيترن ئي ڪارڻن ڪري ڪو به ڪم نه ٿي سگهي ٿو. ڪو به ڪم نه ٿي سگهي ٿو. ڪو به ڪم نه ٿي سگهي ٿو.

முடிவுரை

فصل ۲۷۶

۲۷۰۰ م ۷۶ و ۷۷ م ۷۸ م ۷۹ م ۸۰ م

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ
الحمد لله رب العالمين

[illegible][illegible][illegible]

.. السلامة ..



Сумын Засаг даргын 2024 оны 2 сарын 17-ы
өдрийн 1159 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

МЭРГЭЖЛИЙН АНГИЙН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮН

Сумын онцгой комиссын дарга: С.Энхзул (Засаг дарга)

Сумын онцгой комиссын нарийн бичгийн дарга: Г.Мөнхсүх (ЗДТГ-ын дарга)

Мэргэжлийн ангийн дарга: С.Эрдэнэбаяр (Засаг даргын орлогч)

Хангалт хариуцсан ажилтан: Ш.Хоролсүрэн (Санхүү албаны дарга)

Аюулгүй байдал хариуцсан ажилтан: А.Цэндмаа (Соёлын төвийн эрхлэгч)

Хэв журам хариуцсан ажилтан: Бадарчин (Хэсгийн төлөөлөгч)

Эмнэлэг үйлчилгээ хариуцсан ажилтан: Б.Чулуунтогтох (ЭМТ-ийн дарга)

Сургуулийн захирал: С.Цэдэндорж

Цэцэрлэгийн эрхлэгч: А.Мөнхзул

Цаг уурын мэдээлэл хариуцсан ажилтан: Х.Бямбажаргал (Цаг уурч)

Баримт бичиг хариуцсан ажилтан: Х.Түвшинбилэг (Архив, бичиг хэргийн ажилтан)

Гал түймэр унтраах бүлгийн дарга: Б.Амаржаргал (5-р багийн засаг дарга)

Эрэн хайх аврах бүлгийн дарга: Ч.Өсөхбаяр (Цэцэрлэгийн нярав)

Механикжуулсан хэсгийн ахлагч: А.Гантулга (Хүнс, ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Эмнэлгийн бүлгийн ахлагч: ~~Г.Эрдэнэчимэг (ЭМТ-ийн статистикч)~~ **Б.Эрдэнэцэцэг**,

Анхны тусламжийн бүлгийн дарга: Г.Энхбаяр (Их эмч)

Хөдөө аж ахуйн бүлгийн дарга: Н.Цэрэндолгор (МЭ-ийн улсын байцаагч, тасгийн дарга)

Холбоо зарлан мэдээллийн бүлгийн ахлагч: М.Төмөртоогоо (Соёлын төвийн багш)

Мэдээлэл сурталчилгааны алба: М.Мэндхүү (Газрын даамал)

Нийгмийн хамгааллын бүлэг: Ж.Энхбат (ЭМТ-ийн нийгмийн ажилтан)

Сумын Засаг даргын 2024 оны 2 сарын 17-ы
өдрийн 1 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Мэргэжлийн анги удирдах бүрэлдэхүүн

Мэргэжлийн ангийн дарга: С.Эрдэнэбаяр (Засаг даргын орлогч)

Гал түймэр унтраах бүлэг

Бүлгийн дарга: Б.Амаржаргал (5-р багийн засаг дарга)

Жолооч: П.Норовсамбуу (нярав)

Аврагч: Г.Баасанбат (Технологийн багш)

Аврагч: Б.Гантулга (Биеийн тамирын багш)

Аврагч: С.Мөнхбаатар (Цэцэрлэгийн жижүүр)

Аврагч: Д.Цэндбаяр (Биеийн тамирын арга зүйч)

Аврагч: Д.Батаа (1 дүгээр багийн Засаг дарга)

Эрэн хайх, аврах бүлэг

Бүлгийн дарга: Ч.Өсөхбаяр (Цэцэрлэгийн нярлан бодогч)

Аврагч: Г.Бат-Очир (Биологийн багш)

Аврагч: Н.Тогтохбаяр (Сургуулийн жижүүр)

Аврагч: Ш.Мэндсайхан (Мэдээлэл зүйн багш)

Аврагч: А.Мөнхбадрал (Сургуулийн жижүүр)

Аврагч: Ц.Дуламханд (Цэцэрлэгийн биеийн тамирын багш)

Механикжуулсан хэсэг

Хэсгийн ахлагч: А.Гантулга (Хүнс, ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Жолооч: А.Цэнд-Очир (ЗДТГ-ын жолооч)

Цахилгаанчин: Ц.Цэндцэвээн (ЗДТГ-ын цахилгаанчин)

Жолооч: Б.Энхбат (Сургуулийн цахилгаанчин)

Сантехникч: Г.Хүрэлбаатар (Сургуулийн жижүүр)

Уурын зуухны галч: Х.Уламбаяр (ээлж хариуцсан ажилтан)

Гагнуурчин: С.Амарсанаа (Эрчим хүчний ажилтан)

Гишүүн: Ц.Намхайхорол (2 дугаар багийн Засаг дарга)

Эмнэлгийн бүлэг

Бүлгийн ахлагч: Б.Эрдэнэцэцэг (Багийн эмч)

Их эмч: Ш.Гантулга (Хүүхдийн эмч)

Сувилагч: С.Лхам-Осоржин (Сувилагч)

Сувилагч: Б.Сумъяасүрэн (ЭМТ-ийн сувилагч)

Асрагч: Л.Бат-Ууган (ЭМТ-ийн үйлчлэгч)

Асрагч: П.Дашдулам (ЭМТ-ийн үйлчлэгч)

Хэв журам сахиулах бүлэг

Бүлгийн ахлагч: Б.Бадарчин (Хэсгийн төлөөлөгч)

Идэвхтэн: Л.Пүрэвсүрэн (Хэсгийн цагдаа)

Идэвхтэн: Э.Цэдэвдорж (Олон нийтийн цагдаа)

Идэвхтэн: С.Баттулга (4 дүгээр багийн Засаг дарга)

Анхны тусламжийн бүлэг

Бүлгийн дарга: Г.Энхбаяр (Их эмч)

Жолооч: Б.Ганбаатар (ЭМТ-ийн жолооч)

Идэвхтэн: Г.Зоригт (Эх баригч)

Идэвхтэн: Х.Нарантогтох (Ахлах сувилагч)

Идэвхтэн: Д.Цэнд-Аюуш (сувилагч)

Идэвхтэн: О.Лувсангомбо (Биеийн тамирын багш)

Идэвхтэн: Б.Цэнгэлмаа (Багийн эмч)

Идэвхтэн: Б.Гэрэлмаа (Байгаль орчины улсын байцаагч)

Идэвхтэн: Д.Тогоохүүхэн (Бэлчээр газар тариалан эрхэлсэн мэргэжилтэн)

Хөдөө аж ахуйн бүлэг

Бүлгийн дарга: Н.Цэрэндолгор (МЭ-ийн улсын байцаагч, тасгийн дарга)

Гишүүн: Ж.Оюунтунгалаг (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Б.Болор-Эрдэнэ (Тархвар зүйч)

Гишүүд: А.Элдэв-Очир (3-р багийн Засаг дарга)

Гишүүд: Д.Магнайбаяр (Малын эмч)

Гишүүд: Г.Ерөөлт (Малын эмч)

Холбоо зарлан мэдээллийн бүлэг

Бүлгийн ахлагч: М.Төмөртоогоо (Соёлын төвийн багш)

Холбоочин: Б.Долгорсүрэн (Сэтгэл зүйч)

Холбоочин: Б.Энхчимэг (Соёлын төвийн ажилтан)

Холбоочин: С.Болор-Эрдэнэ (Улсын бүртгэгч)

Холбоочин: Б.Энхтуяа (Сургуулийн англи хэлний багш)

Сургалт мэдээллийн алба

Бүлгийн ахлагч: М.Мэндхүү (Газрын даамал)

Гишүүд: М.Нямжаргал (Бага ангийн багш)

Гишүүд: Б.Адъяасүрэн (Үйлчилгээний оператор, хүний нөөц)

Гишүүд: Б.Даваацэрэн (Газар зүйн багш)

Гишүүд: Б.Балжинням(Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Хангалтын алба

Бүлгийн ахлагч: С.Мөнхцэцэг (Нягтлан бодогч)

Гишүүн: С.Дашзэвэг (ЭМТ-ийн нярав)

Гишүүн: Г.Тунгалаг (ЗДТГ-ын нягтлан бодогч)

Гишүүн: С.Мөнхбат (Цэцэрлэгийн жижүүр)

Нийгмийн хамгааллын бүлэг

Бүлгийн ахлагч: Ж.Энхбат (ЭМТ-ийн нийгмийн ажилтан)

Гишүүн: Н.Мөнхгэрэл (ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүн: Ш.Жаргалмаа (Татварын улсын байцаагч)



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 1/160

Хатан суудал

**Өмчилсөн газрын талбай
хэмжээ залруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.23, Монгол улсын иргэнд Газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн 10/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өөрийн эзэмшил газраа өмчлөх явцад хэмжилтийн алдаанаас шалтгаалж талбайн хэмжээ зөрүүтэй байгаа 2 иргэний өмчлөлийн газрын хэмжээг хавсралтын дагуу залруулсугай.

2. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгч иргэнд, өмчилсөн газрыг улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (М.Мэндхүү)-д, Улсын бүртгэгч (С.Болор-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

4. Энэ захирамжийн хавсралтад тусгагдсан иргэний анхны өмчлөлийн захирамжийн иргэнтэй холбогдох хэсгийн талбайн хэмжээг хүчингүй болгосугай.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642401335



Сумын Засаг даргын 2024 оны 18 дугаар сарын 17-ны өдрийн 18 дугаар захирамжийн хавсралт

Өмчлөгчийн			Өмнөх захирамжийн			Өмнөх газрын		Залруулагдаж буй газрын мэдээлэл				
N	Овог	Нэр	Регистрийн дугаар	Огноо	Дугаар	Хавсралтын баганын дугаар	Нэгж талбарын дугаар	Хэмжээ м2	Нэгж талбарын дугаар	Хэмжээ м2	Газрын байршлын хаяг /шинэчлэгдсэн/	Ашиглалтын зориулалт
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	13	14
1	Ариунбуян	Цэдэндаш	Вв91050814	2014.11.05	140	2	6401000151	868	6401000128	869	Хатан суудал 5-р баг, Жаргалант-11 1103 т	Гэр, орон сууцны хашааны газар
2	Авирмэд	Бурмаа	ВВ63111002	2015.05.07	52	10	6401000707	798	6401000108	993	Хатан суудал 5-р баг, Харзтай-1 102т	Гэр, орон сууцны хашааны газар



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 8/161

Хатан суудал

**Батчулууны Чулуунтогтохыг Эрүүл мэндийн
төвийн даргын албан тушаалд түр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай 11 дүгээр зүйлийн 11.3, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Батчулууны Чулуунтогтохыг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн Эрүүл мэндийн төвийн даргаар түр томилсугай.

2.Д.Нансалмаагаас Б.Чулуунтогтоход ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Эрдэнэбаяр (Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Эрдэнэчимэг (ЭМТөвийн статистикч)

С.Дашзэвэг (Нярав)

Б.Сумъяасүрэн (Бичиг хэргийн эрхлэгч)

Ж.Энхбат (ЭМТөвийн нийгмийн ажилтан)

3.Ажлыг хууль, журмын дагуу хүлээлцэж акт үйлдэхийг ажлын хэсэг (С.Эрдэнэбаярт) үүрэг болгосугай.

4.Б.Чулуунтогтохын цалинг ТҮЭМ-6 зэрэглэл буюу 1,471,000 (Нэг сая дөрвөн зуун далан нэгэн мянга) төгрөгөөр тогтоож, холбогдох нэмэгдлийг хууль журмын дагуу бодож олгохыг Нягтлан бодогч (С.Бадамсүрэн)-д зөвшөөрсүгэй.

5.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг чанд баримтлан, хариуцлагатай ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Чулуунтогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642401337



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 11/162

Хатан суудал

Сумын Засаг даргын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 8/1626 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах саналыг нэгтгэн боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгох ажлын хэсэг томилсугай.

2. Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Эрдэнэбаяр (Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Мөнхсүх (Тамгын газрын дарга)

С.Цэдэндорж (ЕБС-ийн захирал)

А.Цэндмаа (Соёлын төвийн дарга)

А.Мөнхзул (Цэцэрлэгийн эрхлэгч)

Ш.Хоролсүрэн (Санхүү албаны дарга)

Н.Цэрэндолгор (МЭ-ийн тасгийн дарга)

Ж.Оюунтунгалаг (Төсөв, төрийн сангийн

мэргэжилтэн)

Ш.Жаргалмаа (Татварын улсын байцаагч)

А.Гантулга (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

С.Мөнхцэцэг (Сан хариуцсан Нягтлан бодогч)

Б.Гэрэлмаа (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Н.Мөнхгэрэл (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн

асуудал хариуцсан мэргэжилтэн)

М.Мэндхүү (Газрын даамал)

Нарийн бичгийн дарга: Б.Балжинням (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

3. Үйл ажиллагааны хөтөлбөрийн боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан шаардлагын дагуу "Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл"-ийн аргачлалыг баримтлан боловсруулахыг ажлын хэсэг (С.Эрдэнэбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА

С.ЭНХЗУЛ

842401339



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 1/163

Хатан суудал

“Соёлын төвийн номын санг баяжуулах ном”
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх “Соёлын төвийн номын санг баяжуулах ном” хүлээн авах ажилд хяналт тавьж, хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Мөнхсүх -(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Мөнхцэцэг -(Нягтлан бодогч)

А.Батдулам-(Номын санч)

Б.Энхчимэг – (Соёлын төвийн нярав)

Б.Адъяасүрэн- (Үйлчилгээний оператор, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн)

2.Барааг захиалагчтай байгуулсан гэрээний дагуу нийлүүлсэн байдалд хяналт тавьж, нягтлан шалгаж, холбогдох баримт бичгийг боловсруулан сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Мөнхсүх) -д үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг орлогод авч бүртгэхийг байгууллагын нягтлан бодогч (С.Мөнхцэцэг), нярав (Б.Энхчимэг) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (С.Эрдэнэбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642401341



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 1164

Хатан суудал

**“Хүүхдийн цэцэрлэгийг бүрэн камержуулах”
ажилд, хяналт тавьж хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Хүүхдийн цэцэрлэгийг бүрэн камержуулах” ажилд хяналт тавьж, хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Эрдэнэбаяр -(Засаг даргын орлогч)

Гишүүд: Ш.Хоролсүрэн- (Санхүүгийн албаны дарга)
А.Мөнхзул-(Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)
А.Сэлнэн –(Хүүхдийн цэцэрлэгийн нярав)
Б.Бадарчин-(Хэсгийн төлөөлөгч)

2.Барааг захиалагчтай байгуулсан гэрээний дагуу нийлүүлсэн байдалд хяналт тавьж, нягтлан шалгаж, холбогдох баримт бичгийг боловсруулан сумын Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Мөнхсүх) -д үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг орлогод авч бүртгэхийг байгууллагын нягтлан бодогч (Ч.Өсөхбаяр), нярав (А.Сэлнэн) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх) -д даалгасугай.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642491343



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 5/15

Хатан суудал

Г Дашдэлэгийн Зулсаранг Засаг даргын Г
орлогчийн ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.22, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын орлогч Дашдэлэгийн Зулсаранг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Д.Зулсарантай холбогдох санхүүгийн тооцоог бүрэн хийж дуусгахыг Нягтлан бодогч (Г.Тунгалаг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642401305



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 6/16

Хатан суудал

Г Сүхбатын Эрдэнэбаярыг Засаг даргын Г
орлогчоор томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.22, 66 дугаар зүйлийн 66.1, "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2.1, 2.3, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралтаар батлагдсан "Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн болон төрийн улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх албан тушаалын цалингийн хэмжээ"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүхбатын Эрдэнэбаярыг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн Засаг даргын орлогчийн ажилд томилсугай.

2.Д.Зулсарангаас С.Эрдэнэбаярт ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Г.Тунгалаг (Нягтлан бодогч)

Гишүүд: Б.Балжинням (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)
Б.Адъяасүрэн (Үйлчилгээний операторын ажилтан)

3.Ажлыг хууль, дүрэм журмын дагуу хүлээлцэж акт үйлдэхийг комисс (Г.Тунгалаг)-т даалгасугай.

4.С.Эрдэнэбаярын үндсэн цалинг 1,870,000 (Нэг сая найман зуун далан мянга) төгрөгөөр тогтоож, холбогдох нэмэгдлийг бодож олгохыг Нягтлан бодогч (Г.Тунгалаг)-д зөвшөөрсүгэй.

642401307

4.Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журмыг чанд сахиж, хариуцлагатай ажиллахыг Засаг даргын орлогч (С.Эрдэнэбаяр)-д үүрэг болгосугай.



ДАРГА

С.ЭНХЗУЛ



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 5/17

Хатан суудал

Дашцэрэнгийн Нансалмааг Эрүүл мэндийн
төвийн даргын ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 78 дугаар зүйлийн 78.1.9, 82 дугаар зүйлийн 82.1.4, 82.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн дарга Дашцэрэнгийн Нансалмаа нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэж ажлаас чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн тул 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Д.Нансалмаагийн 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 45 хувиар бодож олгох, ажлаас чөлөөлөгдөж байгаатай холбогдуулан ээлжийн амралтын болон санхүүгийн, эд хөрөнгийн эцсийн тооцоог бүрэн хийж дуусган хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцалсны тэтгэмжийг 4 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээгээр тооцон бодож олгохыг Нягтлан бодогч (С.Бадамсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642401355



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 23 өдөр

Дугаар Б/18

Хатан суудал


Соёлын төвийн дарга А.Цэндмаад
үр дүнгийн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны 12 дугаар сарын 13-нй өдрийн 271 дүгээр албан бичгийн дагуу 2024 оны хамтран ажиллах гэрээ, Соёлын төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр хангалттай үнэлгээ авсан Соёлын төвийн дарга Адъяагийн Цэндмаад үр дүнгийн урамшуулал олгосугай.

1. Үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 25 хувиар цалингийн сандаа багтаан бодож олгохыг Нягтлан бодогч (С.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642491351



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 5/19

Хатан суудал

Соёлын төвийн дарга А.Цэндмаад
ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын төвийн дарга Адъяагийн Цэндмаад ур чадварын нэмэгдэл олгосугай.

2.Соёлын төвийн дарга А.Цэндмаад олгох ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 25%-иар тооцон 12 дугаар сард бодож олгохыг Нягтлан бодогч (С.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ЭНХЗУЛ

642401353